

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Г Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 7
193 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны “МИК бондыг бүртгэх тухай” 193 дугаар тогтоолын 1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

“1. “Монголын ипотекийн корпораци” ХХК-ийн энэ тогтоолын хавсралтад заасан тоо хэмжээ, нөхцөл бүхий нэг бүр нь 1 000 000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 25 000 /хорин таван мянга/ ширхэг, орон сууцны барьцаагаар баталгаажсан нийтэд санал болгон гаргах “МИК” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй”.

2. Мөн тогтоолд дор дурдсан агуулгатай 6 дахь заалтыг нэмсүгэй:

“6. Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, хадгалахтай холбоотой тусгайлсан журам баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.”

3. Тогтоолын 6-гаас 9 дэх заалтын дэс дугаарыг 7-гоос 10 болгон тус тус өөрчилсүгэй.

4. Тогтоолд өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН